



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/104

Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээ  
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.2, 38.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаал, 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/133 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээгээ бусдад шилжүүлэх хүсэлт гаргасан 4 иргэн, хуулийн этгээдийн нийт 2.1821га (21821м<sup>2</sup>) газрыг хавсралтаар тус тус шилжүүлэн эзэмшүүлсүгэй

2. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа хуулийн этгээдтэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Мөнгөнзул)-т тус тус зөвшөөрсүгэй.


3. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

4. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



Захирамж 2024  
671:0103:1



ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭГ БУСДАД ШИЛЖҮҮЛСЭН ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭДИЙН ЖАЛГАЛТ

Аймгийн Засаг даргын 2024 оны  
03 дугаар сарын 12-ны өдрийн  
А/104 дүгээр захирамжийн хавсралт

№	Эрх шилжүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн овог, нэр, регистр	Эрх шилжүүлэн авч байгаа иргэн, аж ахуйн нэгжийн овог, нэр, регистр	Нэгж талбарын дугаар	Газрын зориулалт	Газрын байршил, хаяг	Газрын хэмжээ /м2/	Газар эзэмшүүлэх хугацаа	Хучингүй болгож буй захирамжийн дугаар	Тайлбар
1	Чонос овгийн Морхоожий Эрдэнэбаяр (Р083101077)	Анард овгийн Даваахуу Батсайхан (ИЮ92111211)	6712017511	Гэр, орон сууцны хашааны газар	7-р баг 33-13 тоот	301	9	Аймгийн Засаг даргын 2023.05.05-ны өдрийн А/209 дүгээр захирамжийн хавсралтын 2 дахь заалт	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээгээр
2	Жонгоор овгийн Төртогтох Нарангэрэл (РЛ79060203)	Нягт овгийн Энхтүвшин Болдбаяр (РЭ91061017)	6712015123	Гэр, орон сууцны хашааны газар	13-р баг	627	20	Аймгийн Засаг даргын 2017.09.05-ны өдрийн А/578 дугаар захирамжийн хавсралтын 13 дахь заалт	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээгээр, газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа сунгах
3	Цагаан гэрүүд овгийн Цагаанцохио Билэгдэмбэрэл (РУ81121815)	Хурниад овгийн Болдбаатар Дашдондов (ИВ92103031)	6712018065	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар	7-р баг Их-Уул-1 128 тоот	515	24	Аймгийн Засаг даргын 2023.10.11-ний өдрийн 519 дүгээр захирамжийн хавсралтын 12 дахь заалт	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээгээр



4	Боржигон овгийн Самбуу Энхтүвшин (АЯ67040466)	"Хөвсгөл тэвхэн" ХХК (Р.Д.2673398)	6712018026	Аж ахуйн	13-р баг Улаанбаатар явах засмал зам дагуу	20378	24	Аймгийн Засаг Даргын 2023.08.16-ны өдрийн А/438 дугаар захирамж	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээгээр
---	---	--	------------	----------	---	-------	----	---	---

Нийт газрын хэмжээ: 21821м<sup>2</sup>

-----000-----